

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АЖИЛЛАГААНЫ АГУУЛГА, ХӨГЖЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

SIGNIFICANCE OF MONGOLIAN BORDER SECURING OPERATION AND SOME ISSUES ON ITS DEVELOPMENT



В.ЖАВХЛАНЦОГТ

ХСИС-ийн Хилийн сургуулийн захирал, цэргийн ухааны доктор (Ph.D), дэд хурандаа

JAVKHLANTSOGT V.

Director of Border Institute, Law Enforcement University, Ph.D, Lieutenant Colonel



Б.ЛУВСАНРАВДАН

ХСИС-ийн Ахлагчийн сургуулийн Хил хамгаалах албаны тэнхимийн эрхлэгч, докторант дэд хурандаа

LUVSANRAVDAN B.

Ph.D candidate, Lieutenant colonel, head for department of Border Protection service, Non-Commissioned Officer Institute, LEU

Товч агуулга: Монгол Улсын хилийн аюулгүй байдлын агуулыг түүхэн хөгжил, олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлын орчинд дүн шинжилгээ хийх замаар тодорхойлсон. Хилийн аюулгүй байдал нь улс төр дипломатын, эрх зүйн, алба-байлдааны, цэргийн ажиллагааны нэгдэл юм.

Abstract: In this article, we analyzed on significance of Mongolian border security historically, and international or regional security. Border security is a complex of politics and diplomatic, legislation, service-battle and military operation.

Түлхүүр үгс: Монгол Улс, Үндэсний аюулгүй байдал, Оросын холбооны улс, Бүгд найрамдах хятад ард улс, Америкийн нэгдсэн улс, Нэгдсэн үндэстний байгууллага, Хил хамгаалалтын дүрэм.

Key words: Mongolia, National Security, Russian Federation, People's Republic of China, The United State of America, United Nations, the rule of border protection.

Монгол үндэстэн нь 2200 орчим жилийн тэртээ дэлхий дахинаа анхны хилийн шугамыг тогтоон тодорхойлж, хил залгаа улстай харилцан тохиролцсон хэм хэмжээг бий болгож байсан нь орчин үеийн улс, гүрнүүдийн хилийн аюулгүй байдлаа хангах онол арга зүйн үндэс, түүхэн туршлага болсон билээ.

Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах үзэл баримтлал, батлан хамгаалах бодлого, ниймгэм, эдийн засгийн чадавх, хүн ам зүйн бүтэц, олон улсын болон бүс нутгийн улс орнуудын хамтын нийгэмлэгүүдийн хүрээн дэх байр суурь, аюулгүй байдлаа хангах бодлоготой уялдсан онцлог бүхий үйл явц юм. Тиймээс Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны хөгжлийн чиг хандлагыг

тодорхойлохоос өмнө дараах асуудлуудын хүрээнд үнэлгээ хийх зайлшгүй шаардлагатай юм. Үүнд:

- Дэлхий дахины болон бүс нутгийн улс орнуудын аюулгүй байдлаа хангах үзэл баримтлал, орчин;
- Монгол Улсын болон улсын хилийн аюулгүй байдлыг хангах үзэл баримтлал, онол, орчин тус тус болно.

Олон улсын хэмжээнд аюулгүй байдлаа хангах үзэл баримтлал тасралтгүй өөрчлөгдөж, хувьсан хэлбэршиж ирсэн бөгөөд өнгөрсөн зууны сүүлийн хагаст социалист ба капиталист гэсэн хоёр туйлт тогтолцоо байхгүй болсноос хойш дэлхийн улс орнууд аюулгүй байдлын шинэ хувилбарыг боловсруулж эхэлсэн байна. Энэ талаар эрдэмтэн судлаачид янз бүрийн онол, санал, загварыг дэвшүүлж байгаа хэдий ч "Олон туйлт тогтолцоо" гэсэн үзэл баримтлал давамгайлах хандлагатай бөгөөд энэ нь манай улсын хилийн аюулгүй байдлыг хангах ажиллагаанд шууд нөлөөлж байгаа юм.

Аюулгүй байдлыг хангах "Олон туйлт тогтолцоо"-ны бүрэлдэн тогтох үйл явц нь "...хүйтэн дайнаас хойш дэлхийн тавцан дахь нөлөөллийн хүрээг дахин хуваарилснаар олон улсын мөргөлдөөн, зөрчлийн тоо эрс багасч, түүний үр дүнд АНУ нь дэлхийд ноёрхсон хэт их гүрэн болж хувирсан..." [Стратеги судлал. Сэтгүүл. 2008/2. №42.8-10х. 8;]-тай холбоотой байна. Энэ нь зарим улс орны эрх ашиг, гадаад бодлогод шууд нөлөөлсөн бөгөөд ялангуяа Монгол Улстай хил залгаа хоёр гүрний улс төрийн бодлогыг олон улсын төвшинд тогтвортой харилцаа, тэнцвэртэй хүчний харьцааг бий болгох ашиг сонирхолыг бий болгосон нь "Олон туйлт тогтолцоо"-ны үзэл баримтлал бүрэлдэх үндсэн хүчин зүйл болсон байна.

Дэлхийн улс орнуудын аюулгүй байдлыг хангах "Олон туйлт тогтолцоо"-ны агуулга, бүтцийн загварыг дараах байдлаар задлан томьёолсон байна. Үүнд:

- НҮБ, түүний аюулгүйн зөвлөл;
- Бүс нутгийн байгууллагууд;
- Хоёр талын харилцаа;
- Олон улсын хууль эрх зүй гэсэн дөрвөн давхаргаас бүрдсэн

пирамид хэлбэртэй гэжээ [Стратеги судлал. Сэтгүүл. 2008/2. №42.8-10х. 10].

Энэ үзэл баримтлал нь Оросын холбооны улсын 2000 оны 3 дугаар сарын 10-нд баталсан "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал", мөн 2000 оны 6 дугаар сарын 8-нд баталсан "Гадаад бодлогын үзэл баримтлал" баримт бичгүүдэд "Олон улсын үндсэн асуудлуудыг хамтран шийдвэрлэх механизм болон олон улсын хууль эрх зүйг дээдлэх..." [Стратеги судлал. Сэтгүүл. 2009/2. №33.10-14х. 14] гэж тусгагджээ. Мөн ОХУ-ын 2010 онд батлагдсан цэргийн номлолдоо учирч болох гадаад аюул хэмээн 11 зүйл тодорхойлсны дотор "...ОХУ болон түүний холбоотнуудын хил залгаа улсуудад гадаадын цэргийн хүч байрлуулах, тэдгээрийн нутаг дэвсгэрт Нэгдсэн үндэстний байгууллагын дүрэм, олон улсын эрх зүйн хэм хэмжээг зөрчин цэргийн ажиллагаа явуулах..." гэж заасан нь дээрх баримт бичгүүдийн агуулгыг уламжлуулан тодорхойлсон байна гэж үзэхэд хүргэж байгаа юм [Болд.Л. Аюулгүй байдлын орчны өөрчлөлт, улс орны батлан хамгаалах стратеги. УБ., 2011 он. 28х. 10].

Монгол Улстай хил залгаа Бүгд найрамдах хятад ард улс эдийн засгийн хүчин чадал эрс өсөхийн хэрээр аюулгүй байдлаа хангах үзэл баримтлалд өөрчлөлт орж, түүнийгээ "...2008 оноос эхэлж дэлхий дахиныг хамарсан эдийн засгийн хямралыг ашиглан хямд активуудыг ихээр хуримтлуулснаар Америкийн нэгдсэн улс,

Европын Холбооны гадаад өрийн дийлэнхийг эзэмшиж, тэдгээр актив байршиж буй улсуудын бодлогод нөлөөлөх...” [http://www.vip76.mn] байдлаар бүс нутгийн болон дэлхийн улс төрийн давцанд ашиглах бодлого баримталж эхэлсэн нь нийтэд тодорхой болсон. БНХАУ эдийн засгийн хөгжлийн үр дүн цэрэг, улс төр, аюулгүй байдлын байр суурь өөрчлөгдөхөд түлхэц өгч байгаа бөгөөд тэр хэмжээгээр олон улсын тавцанд хатуу байр суурь бүхий бодлого баримтлах боломжийг олгож байна. Тухайлбал: “...Зүүн Азийн, түүний дотор өөрийнх нь улсын эдийн засгийг тэтгэгч газрын тосны нийлүүлэлтийг хангах далайн тээврийн замын аюулгүй байдлыг Хятад улс цэргийн хүчээр сахиж чадна. Өнөөдөр энэ үүргийг гүйцэтгэж байгаа АНУ-ын тэнгисийн цэргийн хүчийг оролж чадахаа, шуудхан хэлбэл, Азийн далай тэнгисийн бүст БНХАУ нь АНУ-гүйгээр хяналтаа тогтоох эрмэлзэлтэй байгааг...” [Болд.Л. Аюулгүй байдлын орчны өөрчлөлт, улс орны батлан хамгаалах стратеги. УБ., 2011 он.28х.12] илэрхийлж байгаа нь БНХАУ-ын бүс нутгийн болон дэлхийн хэмжээнд дахин нэг хүчний туйл болон гарч ирэх зорилготой үйл явцын эхлэл гэж үзэж болох юм. Энэхүү өмнөд хөршийн байр суурийг АНУ-ын Ерөнхийлөгчийн 2012 оны 1 дүгээр сарын 5-нд танилцуулсан Батлан хамгаалахын салбарт явуулах шинэ стратегид цэргийн алба хаагчдын тоог цомхтгож, зардлыг олон зуун тэрбум ам.доллараар бууруулахаар болсон хэдий ч “...Ази-Номхон далайн бүсэд гол анхаарлаа хандуулах...” [www.word.news,mn] болсноо зарласнаар батлагдаж байна.

Монгол Улстай хил залгаа хоёр улс нь харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар аюулгүй байдлын “Олон туйлт тогтолцоо”-ны бас нэгэн туйлыг бүрдүүлэхийг зорьж байгаа нь БНХАУ-ын дарга Ху Жиньтао 2011 оны 6 дугаар сарын 16-нд ОХУ-ын Москва хотод Ерөнхий сайд В. Путинтэй уулзалт хийж хоёр талын хамтын ажиллагааг худалдаа, эдийн засаг, цөмийн болон эрчим хүч, техник технологи, цэрэг батлан хамгаалах зэрэг 5 салбарт хөгжүүлэх чиглэлээр санал бодлоо солилцож, улмаар “...Орос Хятадын хамтын ажиллагааг стратегийн түншийн хэмжээнд хүргэх...” [www.mongol.cri.cn1] гэсэн зорилт дэвшүүлснээс тодорхой харагдаж байна.

Монгол Улсын хил залгаа улсуудын эдийн засаг, батлан хамгаалах салбарт явуулж буй шинэчлэл, хамтын ажиллагаа нь аюулгүй байдлын үзэл баримтлалд гарч буй өөрчлөлтийг хурдасгаж байгаа юм. Гэвч Монгол Улсын аюулгүй байдал, тусгаар тогтнолд шууд заналхийлсан цэргийн аюул хоёр хөршийн болон гуравдагч орны зүгээс одоогоор байхгүй бөгөөд харин дэлхийн эдийн засгийн хурдтай хөгжилтэй уялдан бүс нутгийн аюулгүй байдлын орчинд дараах таагүй өөрчлөлт гарах магадлал байгаа юм. Үүнд:

- Хөрш орнуудын дотоод улс төрийн нөхцөл байдал хурцдах;
- Хил залгаа улсын хил орчмын нутаг дэвсгэрт олон улсын террористууд,зэвсэгт бүлэглэлүүд, салан тусгаарлагчдын үйл ажиллагаа идэвхжих;
- Түүхий эдийн эрэлт хямралт байдалд хүргэх;
- Байгалийн баялгийн төлөөх өрсөлдөөн ширүүсэх;
- Үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэглэлүүдийн зохион байгуулалттай үйл ажиллагаа идэвхжих;
- Эдийн засаг,хүмүүнлэгийн хямрал гарах;
- Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, сүйрэл бий болохзэрэг уламжлалт бус аюул тус тус болно.

Дээрх хүчин зүйл нь улс орны аюулгүй байдлын тогтвортой байдалд сөргөөр

нөлөөлж улмаар Монгол Улсын хил хязгаарын халдашгүй дархан байдалд заналхийлэх, зөрчих, хил орчмын нутаг дэвсгэрт тогтворгүй байдал бий болгох нөхцөлийг бүрдүүлэхэд хүргэж болзошгүй юм. Энэ нь Монгол Улс дэлхий дахины аюулгүй байдлын үзэл баримтлалын хувьсал өөрчлөлт, бүс нутгийн болон хөрш улсуудын олон улсын тавцан дахь байр суурь, батлан хамгаалах бодлого, нийгэм эдийн засгийн хөгжлийн нөлөөллөөс ангид байх боломжгүйг илэрхийлж, харилцан зохицсон, уян хатан бодлого баримтлахыг шаардаж байна. Тиймээс Монгол Улс дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдлыг хангах үзэл баримтлалтай шууд зөрчилдөхгүй байдлаар өөрийн эрх ашгийг хамгаалах, улмаар улсын хил хамгаалалтын ажиллагааг зохион байгуулах арга зам, чиг хандлагыг тодорхойлох нь өнөөдрийн зайлшгүй шаардлага гэж үзэхэд хүргэж байгаа юм.

Монгол Улс 1990-ээд оны үеэс эрх зүйт ардчилсан нийгэм, зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн нь улс орны бүхий л нийгмийн харилцаанд эрс шинэчлэлтийн эхлэлийг бий болгосон нь Монгол Улсын ҮАБ-ын үзэл баримтлалд шууд нөлөөлсөн байна. Манай улс нь 1990 он хүртэлх хугацаанд аюулгүй байдлаа хангах үндсэн чиглэлийг Зөвлөлт Холбоот Улстай тогтоосон цэргийн хамтын ажиллагаан дээр тулгуурлан өмнөд хөрш БНХАУ-ын цэргийн аюул заналаас хамгаалах гэж үзэж байсан. Энэ нь Монгол Улсын хил хамгаалалтыг зөвхөн социалист системийн орнуудын өмнөд хилийг хамгаалах үүргээр тодорхойлоход хүргэжээ. Мөн Монгол Улс зөвхөн Зөвлөлт Холбоот Улсын батлан хамгаалах болон улс төр, эдийн засгийн үйл ажиллагааны шууд хараат байдалтай байсан нь бие даасан гадаад бодлого явуулах боломжийг хязгаарлахад хүргэсэн үндсэн хүчин зүйл байсан хэдий ч нөгөө талаас бүс нутгийн улс орнуудаас үзүүлэх аюул заналын нөлөөллөөс тодорхой хэмжээгээр ангид байлгаж иржээ. Тиймээс хил хамгаалах урлагийн агуулга нь тухайн үеийн социалист системийн орнуудын аюулгүй байдлыг хангах бодлогоор тодорхойлогдоход хүрч байсан. Дээрх нөхцөл байдал нь Монгол Улсын ҮАБ-ыг хангах бодлого, бие даасан үйл ажиллагаа зогсонги байдалд орж, улмаар улсын хил хамгаалалтын арга, хэлбэрийг хуулбарлан хэрэглэхэд хүргэсэн гол нөлөөлөл болсон юм.

Монгол Улсын газар нутгийн байршил төв болон зүүн хойд Ази тивийн хэсэгт хамаарч байгаа бөгөөд энэхүү бүс нутгийн онцлог нь хүн ам, газар нутгийн хэмжээгээр тэргүүлэх БНХАУ, ОХУ болон хамгийн жижиг улс орнуудын тоонд ордог Бруней, Бутан, эдийн засаг, техник технологийн өндөр хөгжилтэй Япон, Саудын Араб, Кувейт, Сингапур, нэн буурай хөгжилтэй Афганистан, Балба, ардчилал хөгжсэн Япон, өмнөд Солонгосын зэрэгцээ хатуу коммунист дэглэмтэй, бүрэн эрхт хаант засаглалтай улс орнууд ч зэрэгцэн байршиж байна. Мөн Монгол Улсын оршин буй бус нутагт дэлхийд цэргийн хүчин чадлаараа тэргүүлэх хэмжээний улсуудын дийлэнх нь оршин байгаа нь "...манай гариг дээр 200 гаруй улс байгаагийн 190-ээд нь өөрийгөө хамгаалах олон талын үүрэг зориулалттай зэвсэгт хүчинтэй байгаа бөгөөд эдгээрээс тав нь (ОХУ-1 сая 240 мянга, Хятад-2 сая 239 мянга, АНУ-1 сая 414 мянга, Энэтхэг-1 сая 300 мянга, Хойд Солонгос-1 сая 100 мянган цэргийн албан хаагчидтай) саяас илүү бие бүрэлдэхүүнтэй байна." [Болдбаатар З. Хөрш орнуудын цэргийн бодлого. УБ., 2005. 127х. 3] гэснээс харагдаж байна. Мөн тус бүс нутагт улс орнуудын хүрээнд цэрэг улс төрийн тогтворгүй байдал тасралтгүй үргэлжилж байгаа бөгөөд тэдгээрээс Ирак, Иран, Афганистанд өрнөж буй дайн, Солонгосын хойгийн хямрал болон баруун Ази тивийн лалын шашинт улсуудад бий болсон дотоодын хямрал, иргэний дайн зэрэг нь тухайн бус нутгийн аюулгүй байдалд

сөргөөр нөлөөлөх хэмжээнд хүрч бүс нутгийн улс орнуудыг тогтворгүй байдалд татан оруулж болзошгүй юм.

Бүс нутгийн хүрээнд цэргийн уламжлалт аюул, занал бодитой оршин байгаа энэ үед уламжлалт бус шинэ аюул заналхийллийн шинэ хэлбэрүүд үүсэн бий болж улмаар тасралтгүй өргөжин тэлж байгаа бөгөөд энэ талаар “...хүний амьдрах орчны бохирдол, байгалийн гамшигт үзэгдэл, дэлхийн цаг агаарын дулаарал, нэн халдварт өвчний тархалт, олныг хамарсан ядуурал, цагаачлал, дүрвэлт, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, мансууруулах бодисын зөөвөр, цөмийн түүхий эд, материал хулгайлах, дамжуулан худалдаалах, үйлдвэрлэх гэх мэт улс орнуудын хилийн шугамаар хязгаарлагддаггүй уламжлалт бус аюулын хүрээ Азид өргөжиж байгаа...” [Паламдорж. Ш. Дайны хувьсал өөрчлөлт, цэргийн урлагийн хандлага. УБ. 2011. 184х. ISBN; 978-99962-50-25-5.DDC.335.02 П-136.53], 8] гэж дүгнэсэн байна. Монгол Улсын гадаад орчин, оршин буй бүс нутгийн цэрэг, улс төр, эдийн засгийн дээрх нөхцөл байдал хилийн цагийн байдлыг хурцатгах хүчин зүйлс бодитой оршиж байгааг нотлон харуулж байгаа юм.

Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь НҮБ болон олон улс, бүс нутгийн хамтын нийгэмлэгүүдийн бодлоготой зохицон Монгол Улсын өөрийн чадавх, боломжид тулгуурлан хэрэгжих зүй тогтолтой. Энэ нь Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг тогтвортой бус хувирамтгай, бүтцийн хувьд гадаад харилцаа, хамтын ажиллагаатай, дотоодын олон төрөл, мэргэжлийн алба, хүчний байгууллагуудын хүч хэрэгсэл оролцсон нийлмэл, Монгол Улсын ҮАБ-ын бүрэлдэхүүн “Оршин тогтнохуйн аюулгүй байдал”-д шууд аюул занал учруулж болзошгүй байдал нь хүчний байгууллагуудын удирдлага, зохион байгуулалтын хувьд нэгдмэл байх шинж чанарыг тус тус бий болгож байгаа юм.

Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь тодорхой зорилго, үүргийн зохицуулалтын зүй тогтолтой, үйлийн цогц нэгдэл байх шинжээрээ үйл ажиллагаанд тулгуурласан тогтолцоот шинж чанарыг агуулж байгаа юм. Тэгэхээр Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг Монгол Улсын ҮАБ-ыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын байгуулалтын тогтолцоо, хүч хэрэгслийн өнөөгийн байдалд тулгуурлан үйл ажиллагааны төлөвлөлтийн тогтолцоог бий болгох замаар шийдвэрлэх нь оновчтой гэж үзэж байна.

Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог тодорхойлохоос өмнө “Тогтолцоо” гэдэг нь ямар агуулгатай болох тухай авч үзэх шаардлагатай юм. Монгол хэлний тайлбар тольд тогтолцоо (систем) гэдэг нь “...аливаа үйл явдал, юмны тодорхой горим...” [www.toli.query.mn] гэж тайлбарласан байна. Мөн батлан хамгаалах салбарын эрдэмтэд бүтээлүүддээ аливаа тогтолцоо нь өөрийн үйл явцын онцлог дээр суурилан бүрэлдэх шинжтэй байх талаар дурдсан байна. Тухайлбал, “...Улсын хил, түүний хамгаалалт нь төрийн бодлого буюу хил хамгаалалтын үзэл баримтлал, эрх зүйн орчин, үйл ажиллагаа гэсэн хоорондоо ихээхэн нарийн шүтэлцээ бүхий тогтолцоотой [Бат-Эрдэнэ Б. Төрөөс Улсын хил, түүний хамгаалалтын талаар баримталсан бодлогыг судалсан нь. ЦУ-ны докторын зэрэг горилсон бүтээл. 2003. 135х. 119], “...Монгол Улсын өөрийгөө хамгаалах бодлого, зарчим нь орон нутгийн хамгаалалтад үндэслэсэн батлан хамгаалах нэгдмэл тогтолцоонд тулгуурлана...” [Болдбаатар З. “Төрийн цэргийн бодлогын үндэс”-д тодотгол, шинэчлэлт хийх шаардлага. Цэргийн шинэчлэл сэтгүүл. УБ., 2009. №2.т. 9-12х. 9], “...батлан хамгаалах тогтолцоо нь ...удирдлагын, ...улс төрийн, ...эрх зүйн, ...нийгмийн, ...эдийн засгийн болон цэргийн тогтолцоонуудаас

бүрдэнэ..." [Отгон-Уул Б. Бүс нутгийн аюулгүй байдал ба Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоо. Цэргийн шинэчлэл сэтгүүл. УБ., 2002. №1.т.4-6х. 4], гэж тус тус үзсэн байна.

Тиймээс Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог нэг талаас Монгол Улсын ҮАБ-ыг хангах эрх ашигтай нийцүүлэн, нөгөө талаас НҮБ, олон улс, бүс нутаг болон хил залгаа улсын аюулгүй байдлаа хангах бодлого, олон улсын эрх зүйн хэм хэмжээтэй зөрчилдүүлэхгүйгээр, өөрийн улсын засаг захиргаа, төрийн болон хүмүүнлэг, хүчний байгууллагуудын харилцан ажиллагаатай явагдах боломжийг хангасан дараах хэсгүүдээс бүрдсэн байдлаар загварчилж болох юм. Үүнд:

1. ҮАБ-ыг хангах болон олон улсын тавцанд баримталж буй бодлого, үзэл баримтлал;
2. Эрх зүйн орчин;
3. Үйл ажиллагаа;
4. Аюулгүй байдлын нөөц тус тус болно.

Монгол Улсын ҮАБ-ыг хангах болон олон улсын тавцанд баримталж буй бодлого, үзэл баримтлал нь олон хүчин зүйлсээс нөлөөлөл дор бүрдэх хэдий ч дэлхийн хамтын нийгэмлэг, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах үзэл баримтлал, орчин болон Монгол Улсын ҮАБ, улсын хилийн аюулгүй байдлыг хангах онол, хэрэгцээ шаардлагаас шууд хамааралтай юм.

Өнөөдөр Монгол Улсын ҮАБ-ыг хангах үзэл баримтлал нь олон улсын эрх зүйн хэм хэмжээг чанд сахих, аливаа маргааныг энхийн аргаар шийдвэрлэх, улс орны хөгжлийн сонголтыг хүндэтгэх зарчим дээр суурилсан "Олон туйлт тогтолцоо"-ны үзэл баримтлалтай агуулгын хувьд нийцсэн байна. Хүмүүнлэг ардчилсан нийгэм, эрх зүйт төрийн хэлбэр бүхий манай улс өөрийн эдийн засгийн хүчин чадал, гадаад аюулгүй байдлын орчин зэрэг хүчин зүйлсийг харгалзан аюулгүй байдлаа хангах үндсэн чиглэл нь олон улсын нийтлэг зарчим, хэм хэмжээг хүндэтгэн сахиж олон улсын тавцан дахь нэр хүнд, байр сууриа бэхжүүлэх нь ҮАБ-ыг хангах үзэл баримтлалын гол агуулга болж байгаа юм.

Монгол Улсын хилийн бүс, зурваст бий болсон асуудлыг шийдвэрлэх ажиллагаа нь улсын хил хамгаалалттай шууд холбогдон тодорхойлогдох нь зайлшгүй. Тиймээс улсын хил хамгаалалтын онол, арга зүйн чиг хандлагыг ҮАБ-ыг хангах үзэл баримтлалтай холбон шинжлэх шаардлагатай юм.

Улсын хил хамгаалалт нь өргөн утга санааг агуулсан ойлголт бүхий үйл явц бөгөөд байгаль, нийгмийн үзэгдлийн хүрээнд бий болж буй бодит хүчин зүйлсийн нөлөөн дор хувьсан өөрчлөгдөж байдаг зүй тогтолтой юм. Улсын хил хамгаалалт нь "Улс", "Хил", "Хамгаалалт" гэсэн бие даасан ойлголтын нийлэмжээс тогтох бөгөөд "Улсын хил" гэсэн хүн төрөлхтний нийгэм, улс төрийн олон талт харилцаанд суурилсан агуулгыг илэрхийлж байна.

"Хил" хэмээх ойлголт нь дангаараа өргөн утгатай ч "Улсын хил" гэсэн нийлэмж нь хүн төрөлхтний нийгэмших үйлийн үр дүнд бий болсон нийгэм-улс төрийн тогтолцооны дээд байгууламжийн зах хязгаарын хэмжигдэхүүн байдлаар тодорхойлогдож байна. Улсын хил хөрш улс болон бусад орнуудын харилцан хүлээн зөвшөөрлийн үндсэн дээр тогтоогддог зүй тогтолтой шинжээрээ олон улсын эрх зүйн хэм хэмжээний үндсэн агуулга болдог. Мөн тусгаар тогтносон улс гэсэн ойлголтонд дараах дөрвөн шинжийг агуулсан байхыг үндэслэл болгодог. Үүнд:

1. "...Өөрийн газар нутагтай байх;

2. Бүрэн эрхт байдлыг хадгалсан байх;
3. Улс төрийн засаглалтай байх;
4. Харьяат иргэдтэй байх...” [Дашдэлэг.Ч. Хилийн асуудлууд. УБ., 2008., 210х. 6] тус тус болно.

Аливаа улс орон бүхэн өөр хоорондоо харилцан адилгүй нийгэм, улс төрийн хэлбэртэй байх боловч оршин тогтнохуйн үндэс болсон газар нутаг түүний бүрэн бүтэн байдлыг хамгаалах үзэл санаа, хэрэгцээ шаардлага ижил байдаг.

Улсын хил нь олон улсын эрх зүйн харилцааны үндсэн ухагдахуун бол “Хамгаалалт” хэмээх ойлголт нь хил залгаа хоёр улсын үндэсний эрх ашгийг олон улсын эрх зүйн хэмжээний хүрээнд хэрэгжүүлж буй эрх бүхий субъектийн онцгой үйл ажиллагаа гэж хэлж болно. Энэ талаар Монгол Улсын хилийн тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 30 зүйлд “Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хилийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хилийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн бүс, зурваст Улсын хил хамгаалах байгууллагаас улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, цэргийн, инженер-техникийн, улс төр, дипломатын, эдийн засгийн, тагнуулын зэрэг арга хэмжээг хослуулан явуулж байгаа үйл ажиллагааг улсын хил хамгаалалт гэнэ...” хэмээн тодорхойлсон. Тодорхойлолтын агуулгад заасан “Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах...” үйл ажиллагаа нь өөрөө “...хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр...”, “...хилийн тухай хууль, тогтоомж...”-ийг хэрэгжүүлснээр хангагдаж байхаар заасан байна. Өөрөөр хэлбэл, эдгээр хууль, тогтоомжын агуулга нь “Улсын хилийн халдашгүй дархан байдал” хэмээх ойлголтыг бүрдүүлж байна гэж үзэж болох юм. Тэгэхээр “...хилийн зөрчил...” нь “Улсын хилийн халдашгүй дархан байдал”-ыг бүрдүүлж буй дээрх хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл, түүнийг “...илрүүлэх, таслан зогсоох...” ажиллагаа нь эрх бүхий байгууллагаас авах арга хэмжээний хэлбэрүүд байна. Дээрх үнэлэлтэд үндэслэн “Улсын хилийн халдашгүй дархан байдал” нь улсын хилийг хоёр улсын эрх бүхий субъектүүд харилцан тохирч, зохих журмын дагуу баталгаажуулснаар бүрэлдэн тогтох зүй тогтолтыг дипломат харицлаа бүхий үйл явцаар хангах бөгөөд “Улсын хил хамгаалалт” нь тайван цагт “...хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр...”, “...хилийн тухай хууль, тогтоомж...”-ийг хэрэгжүүлэх ажиллагаа байна гэж болох юм.

Улсын хил хамгаалалтын үйл ажиллагаа нь олон улсын гэрээ, хэлэлцээр, хууль тогтоомжийг сахиулах агуулгатай байгаа нь дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдлыг хангах “Олон туйлт тогтолцоо”-ны “Олон улсын хууль эрх зүй”-н хэм хэмжээнд суурилж НҮБ, түүний аюулгүйн зөвлөл болон олон улсын дэмжлэгт тулгуурлан явагдах зарчимтай шууд нийцэж байна. Гэвч Монгол Улсын хил хамгаалалт нь дангаар хууль сахиулах үйл ажиллагаа биш бөгөөд улсын хил орчмын нутаг дэвсгэрийн хүн ам сийрэг суурьшилтай, дэд бүтэц сул хөгжилтэй, байгаль, цаг агаар, газар зүйн болон гадаад дотоод цагийн байдлын эрс ялгаа бүхий өргөн уудам орон зайд байрласан “...улсын хилийн 8 мянга гаруй км урт хэсгийг зөвхөн цэргийн хүч хэрэгсэл, үйл ажиллагаагаар хамгаалах боломжтой...” [Жавхланцогт В. Дүрвэгсэд ба улсын хилийн аюулгүй байдлын зарим асуудал. Хилчин сэтгүүл. УБ., 2012.12 сар. №11, 12 (50,51). 24] нь тодорхой байдаг. Мөн Монгол Улсын батлан хамгаалах эрх ашиг, бодлого, стратеги нь ай төрлийн цэргийн хүч хэрэгслээр улсын хил хамгаалалтыг зохион байгуулахыг шаардаж байгаа бөгөөд “Монгол

Улсын Батлан хамгаалах номлол"-ын агуулгаар баталгаажсан ойлголт юм.

Тэгэхээр дээрх хүчин зүйлст үндэслэгдэн Монгол Улсын хил хамгаалалтын хэлбэрийн хувьд дипломат гадаад харилцаа, хууль зүйн болон цэргийн ажиллагаа шатлан явагдах зүй тогтолтой байгаа нь ҮАБ-ыг хангах онцгой салбар болохыг илэрхийлж байгаа юм.

Монгол Улсын хил хамгаалалтын дээрх онцлог нь хил хамгаалалтын хэлбэрүүдтэй уялдан шатлан хэрэгжих дипломат харилцаа-хууль сахиулах-батлан хамгаалах үйл ажиллагааны шинжийг илэрхийлж байна гэж үзэхэд хүргэж байгаа юм. Тиймээс Монгол Улс өнөө ба ойр ирээдүйд Хил хамгаалах байгууллага улсын хил хамгаалалтын явцад үүссэн аливаа үйл явц (үзэгдэл)-ыг олон улсын эрх зүйн нийтлэг хэм хэмжээг баримтлан үндэсний аюулгүй байдлыг хангах эрх ашигтай нийцүүлэн шийдвэрлэх дипломат харилцаа улмаар үүсэн бий болж болзошгүй хамгийн хүнд цагийн байдалд үүрэг гүйцэтгэх чадавхтай буюу хил орчмын дэглэм сахиулах хууль зүйн ажиллагаанаас улсын хилийг халхлах цэргийн ажиллагаанд шилжин ажиллах дараалал бүхий ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байгаа нь тодорхойлогдож байна.

Энэхүү онцгой чиг үүргийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрэн хангагдсан гэж үзэх боломжтой байна. Монгол Улсын хил, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн орчин нь нэг талаас олон улсын аюулгүй байдлаа хангах үзэл баримтлал, зарчмыг илэрхийлсэн актууд, нөгөө талаас Монгол Улсын өөрийн аюулгүй байдал, ашиг сонирхлоо хангах үйл ажиллагааны хэв загвар, албадлагын хэмжүүрийг илэрхийлсэн актууд гэсэн хоёр бүлгээс бүрдэх нь тодорхой харагдаж байгаа бөгөөд дараах байдлаар авч үзэх шаардлагатай юм. Үүнд

1. Олон улсын эрх зүйн орчин;
2. Монгол Улсын үндэсний эрх зүйн орчин тус тус болно.

Олон улсын эрх зүйн орчинг Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан олон улсын гэрээ, конвенци, протоколуудын хэм хэмжээ бүрдүүлдэг бөгөөд өнөөдрийн байдлаар манай улсын хилийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр нийт 50 гаруй гэрээ, хэлэлцээрээр зохицуулагдаж байна.

Монгол Улсын үндэсний эрх зүйн орчинг өөрийн улсын дотооддоо үйлчлэхээр батлагдан мөрдөгдөж буй хууль, тогтоомжуудаар бүрдүүлж буй бөгөөд тэдгээрийн хэм хэмжээ нь хуулийн хүчин чадал буюу шатлан захирагдах шинжээрээ дараах байдлаар ангилагддаг. Үүнд:

1. "...Үндсэн хуулийн хэм хэмжээ;
2. Хуулийн хэм хэмжээ;
3. Хуульчилсан актын хэм хэмжээ..." [Нямсүрэн Ч. Эрх зүй, Төрийн ерөнхий онол. УБ., 2001. 354х. 75] тус тус болно.

Аливаа улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын гол шалгуур үзүүлэлтийн нэг нь өөрийн гэсэн газар нутаг, хил хязгаартай, тэдгээр нь халдашгүй дархан байх орчин, нөхцөл бүрдсэн байх явдал юм. Тиймээс ч 1992 онд 6 бүлэг, 70 зүйлтэйгээр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр бүлгийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна" [www.mongolianlaws.com] гэж заасан нь манай улсын хилийн аюулгүй байдлын эрх зүйн орчин бүрэлдэх үндсэн суурь заалт болсон. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх хэм хэмжээг "...Нутаг дэвсгэр бол аливаа улс орон бие даан оршин тогтнох материаллаг үндэс. Мөн улс бүр өөрийнхөө нутаг дэвсгэрийн хязгаар дотор онцгой бүрэн эрхийг эдлэх бөгөөд үүнийг нутаг

дэвсгэрийн дээд эрх хэмээнэ. Нутаг дэвсгэрийн дээд эрх бол тухайн улс гүрний онцгой чухал эрх, тусгаар тогтнолын баталгаа юм.” [Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ., 2009. 241х. 22] хэмээн тайлбарлан баталгаажуулсан байна. Энэ нь Монгол Улсын хил хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг бүрэлдэн бий болох үндсэн суурь хэм хэмжээ болсон бөгөөд эрдэмтэн судaalчид “Монгол Улсын язгуур ашиг сонирхлын бүрэлдэхүүнд хил хязгаар, нутаг дэвсгэрийн халдашгүй, бүрэн бүтэн байдлыг цогц байдлаар хамааруулсан нь хилийн аюулгүй байдлын эрх зүйн орчныг боловсронгуй болгох төрийн бодлого...” [Улсын хилийн аюулгүй байдал ба хамтын ажиллагаа. ОУЭШХ-ын эмхтгэл. УБ., 2012. 330х. 28] гэж үзсэн нь аюулгүй байдлын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудал Монгол Улсын Төрийн бодлогын чухал чиглэл болохыг харуулж байна.

Монгол Улсын ҮАБ-ын үзэл баримтлал болон Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал зэрэг бодлогын чанартай, тодорхойлж, тунхагласан хэм хэмжээ бүхий баримт бичгүүд нь дэлхийн улс орнуудын аюулгүй байдлаа хангах “Олон туйлт тогтолцоо”-ны үзэл баримтлал, зарчимтай нийцсэн агуулгатай болсон байна.

“Монгол Улсын Төрийн цэргийн бодлого”, “Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого” баримт бичгүүд нь Монгол Улсын ҮАБ-ын үзэл баримтлал, бодлогын салшгүй хэсэг, агуулгын залгамж чанартай байгаа юм.

Монгол Улсын Хил хамгаалах байгууллага нь “Монгол Улсын Үндсэн хууль”, “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай” болон хуулиудад заасны дагуу улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй бөгөөд Монгол Улсын ХХБ-ын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоосон “Хил хамгаалалтын дүрэм”-ийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 307 тоот зарлигаар шинэчлэн баталсан.

Монгол Улсын хил хамгаалалтын үйл ажиллагааг Хил хамгаалах дүрэмд тус бүрдээ авах арга хэмжээ, оролцох хүч хэрэгслээрээ ялгаатай дараах хэлбэрүүдээр зохион байгуулахаар тодорхойлсон байна. Үүнд:

1. Ердийн хил хамгаалалт;
2. Хүч нэмэгдүүлсэн хил хамгаалалт;
3. Онцгой нөхцөл байдлын үеийн хил хамгаалалт тус тус болно.

Улсын хилийн ердийн хамгаалалтын талаар тусгайлан тодорхойлсон заалт хууль тогтоомж, дүрэм зааварт байхгүй байгаа бөгөөд зарим эрдэмтэн, судлаачид “...Монгол Улсын хилийн тухай хуульд заасанчлан байнгын бэлэн байдалтайгаар хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, улсын хилийг манах, хил залгаа улсын хил хамгаалах байгууллагатай Хилийн төлөөлөгчийн шугамаар хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулах зэрэг үүргийг гүйцэтгэхээр Хил Хамгаалах байгууллагаас хил хамгаалалтанд тусгах хүчний гишүүд, орон нутгийн ард иргэд, байгууллагуудтай нягт харилцан ажиллагаатай цогцолбор арга хэмжээ...” [Лхагвасүрэн М. Монгол Улсын хил хамгаалах Хилийн хорооны ажиллагаа. УБ., 2001. 231х. 3] гэж тодорхойлсон байдаг.

Улсын хилийг хүч нэмэгдүүлэн хамгаалах гэдэг ойлголтыг Хил хамгаалах дүрмийн 5 дугаар бүлгийн 90 дугаар зүйлд “...хариуцсан хэсгийнхээ хамгаалалтын гүн, нягтралыг нэмэгдүүлэх, цэргийн хяналт, газар орон дээр хийх үзлэг шалгалтыг идэвхжүүлэх, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах арга хэмжээг чангатгах, бие бүрэлдэхүүний албаны бэлэн байдал, сонор сэрэмжийг дээшлүүлэхэд чиглэгдсэн цогц арга хэмжээ...” [Хил хамгаалах дүрэм (I хилийн отряд). УБ., 2007

он,105х. 78] гэж заасан байна.

Хил хамгаалах дүрмийн 9 дүгээр бүлгийн 187 дугаар зүйлд "Онцгой байдлын үеийн хилийн отрядын хил хамгаалалт" гэдэг нь "...улсын хилийн зурвас, бүсэд байгалийн гамшиг, аюулт үзэгдэл тохиолдох, эмх замбараагүй байдал үүсэх, иргэд бөөнөөр хил нэвтрэхийг завдах, алан хядах, хорлон сүйтгэх ажиллагаа явагдах, өдөөн хатгалга, зэвсэгт халдлага, түрэмгийлэл үйлдэгдэх нөхцөл байдал бий болсон үед Хил хамгаалах байгууллагаас явуулах цогц үйл ажиллагааг онцгой байдлын үеийн хил хамгаалалт гэнэ..." [Хил хамгаалах дүрэм (I хилийн отряд). УБ., 2007 он, 105х. 63] гэж тодорхойлсон байна.

Хил хамгаалах дүрэмд тодорхойлсон "Онцгой байдал" нь Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 2-т "...онцгой нөхцөл бий болсон үед үр дагаврыг нь арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд онц байдал зарлаж болно..." [Төрийн мэдээлэл. Сэтгүүл. УБ. 1992.01.20., №1 /39/, 15] гэсэн заалттай агуулгын хувьд нийцэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2-ын 1 дэх хэсэгт "Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон", тус зүйлийн 2-ын 2 дахь хэсэгт "Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохиуулах боломжгүй болсон." гэж тус тус заасан. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь нийтийн эмх замбараагүй байдал үүсч, зэвсэгт мөргөлдөөнд хүрсэн, тийм мөргөлдөөн гарах бодит аюул бий болсон, бусад улсаас цэргийн хүчээр түрэмгийлэн халдсан, эсвэл тийнхүү халдах нь бодитой болсон үед дайны байдал зарлаж болно." [Өнөрбаяр Э. Үндсэн хуулийн эрх зүй. Хуульчдын сонгон шалгаруултад зориулсан тусгай эмхтгэл. УБ., 2010., 396. 12] гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 2, 3 дугаар хэсэгт заасан дээрх агуулга нь үүсэн бий болсон тухайн цагийн байдлын үедавах арга хэмжээг тодорхойлох эрх зүйн орчин бүрэлдэх шалтгаан нөхцлийг дараах байдлаар ялгамжтай байхаар заасан байна. Үүнд:

1. Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 2-ын 1 дэх ба 2 дахь хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн үед хүчний байгууллагуудын харилцан ажиллагаатай аюулгүй байдлыг дотоодын шинжтэй тусгай үйл ажиллагаа явуулах ба Онц байдлын тухай хуулиар;

2. Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 3-т дотоодод бий болсон нийтийн эмх замбараагүй байдал зэвсэгт мөргөлдөөнд хүрсэн байх болон гаднаас цэргийн хүчээр халдсан ба халдаж болзошгүй болсон асуудлыг Дайны байдлын тухай хуулиар тус тус зохицуулахаар тодорхойлсон байна.

Тэгэхээр Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн үед Онц байдлын тухай хуулиар, 25 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн үед Дайны байдлын тухай хуулийн хүрээнд хоорондоо эрс ялгаатай арга хэмжээг зохион байгуулж, явуулах эрх зүйн орчинг тус тус бүрэлдүүлсэн ба эдгээр хууль нь өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Тиймээс Хил хамгаалалтын дүрэмд тодорхойлогдсон "Онцгой байдлын үеийн

хил хамгаалалт” нь Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн заалттай харьцуулан авч үзвэл “Онц байдал” ба “Дайны байдал” тогтоох үндэслэл бүхий нөхцөл байдалд Хил хамгаалах байгууллагаас 2 өөр хэлбэр, чиглэл, зорилготой явагдах арга хэмжээг нэгтгэсэн байгааг дараах байдлаар ангилан авч үзэх шаардлагатай байна. Үүнд:

А. Монгол Улсын Онц байдлын тухай хуулийн хүрээнд зохицуулагдах онцгой нөхцөлд:

- Гамшигт үзэгдэл тохилдох;
- Эмх замбараагүй байдал үүсэх;
- Иргэд бөөнөөр хил нэвтрэх, нэвтрэхийг завдах (дүрвэгсэд, нэрвэгдэгсэд, цагаачлагчид байж болох);

Б. Монгол Улсын Дайны байдлын тухай хуулийн хүрээнд зохицуулагдах онцгой нөхцөлд:

- Алан хядах, хорлон сүйтгэх ажиллагаа явагдах;
- Өдөөн хатгалга үйлдэгдэх (зэвсэггүй бөөн иргэд өдөөн хатгалга үйлдэх);
- Зэвсэгт халдлага үйлдэх;
- Түрэмгийлэл үйлдэгдэх тус тус болно.

Дээрх ангилалаас онцгой нөхцөл байдал нь хөрш болон олон улсын хэмжээнд улс төр, дипломатын үйл ажиллагаа хямралт байдалд хүрч улс орны нийгэм, улс төр, эдийн засгийн байгуулалт дайнд бэлтгэхэд хүрсэн нөхцөл байдлууд нь манай улс өөрийн дотооддоо үүссэн, өөрийн хүчний байгууллагуудын хүч хэрэгслээр зохицуулах боломжтой “Онц байдал”-ын үеийн ажиллагаатай нэг ангилалтад хамааруулах боломжгүй юм. Тиймээс хил хамгаалалтын хэлбэрүүдэд тодотгол хийх шаардлагатай байгааг илэрхийлж байна гэж үзэхэд хүргэж байна. Дээр дурдсанчлан олон улсын хэмжээний аюулгүй байдлыг хангах үзэл баримтлалын хувьсал, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах эрх ашиг, сонирхол, олон улсын болон үндэсний эрх зүйн хэм хэмжээтэй уялдуулан Улсын хил хамгаалалтын хэлбэрийг дараах байдлаар 5 хэсэгт хуваан авч тодорхойлох нь зүйтэй юм. Үүнд:

1. Ердийн хил хамгаалалт;
2. Хүч нэмэгдүүлсэн хил хамгаалалт;
3. Онцгой байдлын үеийн хил хамгаалалт;
4. Дайн бүхий байдлын хил хамгаалалт;
5. Дайны байдлын үеийн хил хамгаалалт тус тус болно.

Улсын хил хамгаалалт нь дээрх хэлбэрүүдээр шатлан хэрэгжиж байдаг зүй тогтолтой бөгөөд ХХБ нь чиг үүрэгтэйгээ нийцсэн бүтэц, зохион байгуулалт, зэвсэг техник, ажиллагааны арга тактик, бэлтгэл сургалт нь хамгийн хүнд цагийн байдлын үед үүрэг гүйцэтгэх боломж, чадвартай байхад чиглэгдсэн байх шаардлагатай юм.

Тиймээс Монгол Улсын ҮАБ-ыг хангах үйл ажиллагааны талаар ойлголтыг дараах шаталсан бүрдэл хэсэг байдлаар тодорхойлох шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1. Монгол Улсын үндэсний үнэт зүйлс;
2. Монгол Улсын үндэсний эрх ашиг;
3. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого;
4. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа (төлөвлөлт);

5. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн орчин;

6. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны байгуулалт;

7. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг тус тус болно.

Дүгнэлт

НҮБ, дэлхий дахин болон бус нутгийн улс орнуудын үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, Монгол Улсын ҮАБ хангах үзэл баримтлал түүний туршлага сургамж, өнөөгийн боломж, эрх зүйн орчны хүрээнд хийсэн тойм судалгааны үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Монголын түүхэнд оршин тогтнож байсан улс гүрнүүдийн эзэмшиж байсан газар нутгийн хилийн талаарх түүхэн баримт, мэдээллийг мушгин гуйвуулах нь тухайн газар нутгийг эзэмшиж байгаа гүрний үндэсний эрх ашиг болох нь харагдаж байна;

2. Монгол Улсын хилийг хил залгаа улсад оршин амьдарч буй Монгол үндэстнүүд хүрээлж байгаа нь аливаа сөрөг хүчин зүйлсийн түрэлтэд хаалт болж байгаа нь Хилийн аюулгүй байдлыг хангах асуудлыг "Гадаад ба дотоод орон зай"-д явагдах байдлаар ангилах шаардлагатай юм. Гадаад орон зай дахь үйл ажиллагаа нь Монгол Үндэсний түүх, соёл урлаг, ёс заншил, хэлийг хамгаалах, бахархан дээдлэх үзэл санааг хөгжүүлэн өвлүүлэхэд чиглэгдэнэ. Энэ нь "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын "...Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндэс нь Үндэсний эх оронч үзэл санаа байна..." гэсэн заалттай нийцэж байна;

3. Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь нэгдүгээрт Монгол Улсын Засгийн газраас явуулж байгаа олон улсын хэмжээний улс төр, дипломат гадаад харилцааны ажиллагаа, хоёрдугаарт тайван цагт Монгол Улсын болон олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн бүс зурваст хууль сахиулах ажиллагаа, гуравдугаарт Монгол Улсын хилийн орон зайд бий болж болзошгүй цагийн байдлын өрнөлтийн нөхцөлд явуулах алба-байлдааны ажиллагаа, цагийн байдал хүндэрсэн үеийн ажиллагааны бэлэн байдлыг хангаж буй Монгол Улсын Батлан хамгаалах нэгдсэн тогтолцооны бүрэлдэхүүнд байх цэргийн ажиллагаа гэдэг нь тодорхой байна.